| 210604 | Урсгал засвар | 13,000,000.00 | (13,000,000.00) |
| 2107 | Томилолт, зочны зардал | 720,000.00 | (720,000.00) |
| 210702 | Дотоод албан томилолт | 720,000.00 | (720,000.00) |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 28,944,400.00 | (28,944,400.00) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 28,594,400.00 | (28,594,400.00) |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 350,000.00 | (350,000.00) |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 113,452,800.00 | (113,452,800.00) |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 110,240,400.00 | (110,240,400.00) |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,212,400.00 | (3,212,400.00) |
| | ХӨТӨЛБӨР 71902 | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 80103 | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 11,000,000.00 | (11,000,000.00) |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 11,000,000.00 | (11,000,000.00) |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 11,000,000.00 | (11,000,000.00) |
| 2105 | Нормативт зардал | 3,800,000.00 | (3,800,000.00) |
| 210502 | Хоол, хүнс | 3,800,000.00 | (3,800,000.00) |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 7,200,000.00 | (7,200,000.00) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,200,000.00 | (7,200,000.00) |
| | ХӨТӨЛБӨР 71902 | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 80918 | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 99,759,600.00 | (99,759,600.00) |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 99,759,600.00 | (99,759,600.00) |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 99,759,600.00 | (99,759,600.00) |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,759,600.00 | (99,759,600.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 99,759,600.00 | (99,759,600.00) |
| | ХӨТӨЛБӨР 72102 | - | - |
| | АРГА ХЭМЖЭЭ 80101 | - | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 600,000.00 | (600,000.00) |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 600,000.00 | (600,000.00) |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 600,000.00 | (600,000.00) |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 600,000.00 | (600,000.00) |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 600,000.00 | (600,000.00) |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 303,950,000.00 | (303,950,000.00) |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 303,950,000.00 | (303,950,000.00) |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 241,000,000.00 | (241,000,000.00) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 51,950,000.00 | (51,950,000.00) |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,000,000.00 | (11,000,000.00) |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 58,301.00 | (57,281.00) |
| 620001 | Удирдах ажилтан | 7,878.00 | (7,323.00) |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 4,545.00 | (4,090.00) |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 45,878.00 | (45,868.00) |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

**<u>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар</u>*:***

Завхан аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, Нийгмийн халамжийг оновчтой болгон, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлнэ” гэсэн зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

**<u>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар *зорилго*</u>**

- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүртээмж, чанар үр ашгийг дээшлүүлж тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, хөдөлмөрлөх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэх замаар ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.*
- *Хүн амын зорилтот бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар нийгмийн халамж хүртэгчээс хөдөлмөр эрхлэгч болгох нөхцлийг бүрдүүлэх, ядуурлын түвшинг бууруулах*
- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн төсөвлөлт, зарцуулалт, тайлагналтыг ил тод нээлттэй болгож, хяналтыг сайжруулах*
- *Бодлогын хэрэгжилтийн явц, байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, төлөвлөлт, гүйцэтгэл, үр ашиг, үр нөлөөг нэмэгдүүлэх.*

*Байгууллагын 2024 оны жилийн гүйцэтгэлийн төлөвгөөнд 6 зорилтын хүрээнд 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97 хувийн гүйцэтгэлтэй гэж үнэлсэн байна.*

**3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

**<u>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын</u>** *үйл ажиллагаанд мөрддөг хууль:*

1. Төрийн албаны тухай хууль
2. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
3. Төсвийн тухай хууль
4. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
5. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
6. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
7. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
8. Хөдөлмөрийн тухай хууль
9. Төрийн хэмнэлтийн тухай хууль
10. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус газар нь дотоод хяналт зөвлөл нь 2024 оны ажлын төлөвлөгөөндөө 18 ажил хийхээр төлөвлөсөн байна.Төлөвлөгөөний дагуу хяналт шалгалт бүрд удирдамж батлуулж, хяналтаар илэрсэн зөрчлийг арилгаж ажилласан байна. Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл болон мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 123,698.0 мянган төгрөгөөр буюу 13,9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* *Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 134.9 | - | - |
| Бараа материал | 7,612.2 | 34,427.6 | 26,815,4 |
| Үндсэн хөрөнгө | 966,020.4 | 1,065,903,0 | 99,882,6 |
| **Нийт хөрөнгө** | **973,767.5** | **1,100,684.0** | **126,698.0** |
| Өр төлбөр | 1,205,458.0 | 417,210.0 | **788248.0** |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 972,562.1 | 1,100,266,800.3 | 119,402.7 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **973,767.5** | **1,100,684.0** | **123,698.0** |

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

**Тайланд онд:**

**Үндсэн хөрөнгө:** Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны 08 дугаар сарын 26-ны А/310 тоот тушаалаар 18 ширхэг таблет/ нийт 19,422.0 мянган төгрөгийн төгрөгийн тавилга тоног төхөөрөмж, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын даргын 2024 оны 09 дүгээр сарын 18-ний өдрийн А/339 дүгээр тушаалаар суурин компьютер 28 ширхэг, принтер 2 ширхэг, зөөврийн компьютер 1 ширхэг, нийт 81,385.6 мянган төгрөгийн нийт үнэ төлбөргүй 100,807.6 мянган төгрөгийн өгрөгийн тоног төхөөрөмж орлогод авч бүртгэсэн. Мөн тус онд 55,190.0 мянган төгрөгийн үнэ бүхий тавилга, эд хогшил, 10,000.0мянган төгрөгийн 3 ширхэг суурин компьютер, 17,000.0 мянган төгрөгийн 1 зөөврийн компьютер, 1 ширхэг Ухаалаг дэлгэц, 1 ширхэг угтвар ширээ, 1 ширхэг хурлын ширээ, 6 ширхэг хурлын сандал, 500.0мянган төгрөгийн хяналтын камер нийт 82,690.0 мянган төгрөгийн хөрөнгийг урсгал зардлаас худалдан авч албан хэрэгцээнд ашиглаж байна.

**Бараа материал:** Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын даргын А/31-А/74 тоот тушаалаар эд хөрөнгийн тооллого жилд 2 удаа зохион байгуулж тооллого хийх явцад байгууллагын эзэмшилд байгаа эд хөрөнгийг газар дээр нь нүдээр үзэн тоолж ажилласан. Тайлант онд нийт үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгө 109,002.1мянгант өгрөгийн хөрөнгө, 82,690.0 мянган төгрөгийн худалдан авсан хөрөнгийг орлогод авч 144,797.0 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулалтын дагуу зарлагад бүртгэсэн. 8,302.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө буюу газрыг үндсэн хөрөнгөнд бүртгэж авсан.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,997,796.2 мянган төгрөг, нийт зарлагыг 2,154,419.7 мянган төгрөг тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл тодотголоор нэмж баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг санхүүжүүлэхээр 13,616.8 мянган төгрөгийг улсын төсвөөс төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,659,277.2 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байна. Энэ нь хангамж бараа үйлчилгээний зардал 824.8 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

***Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл***

*/мянган төгрөгөөр/*

| Хөтөлбөр арга хэмжээ | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| **Улсын төсвөөс санхүүжих** | | | | | |
| **71902** | **ХХААХҮЯам** | | | | |
| **80101** | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,660,174.7 | 1,659,277.2 | 897.5 | 99,9 |
| 80103 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 631.6 | 740.5 | 108,9 | 117 |
| 80802 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал | 250.0 | 250.0 | 94.18 | 91,6% |
| 72102 | | 244.3 | 244.3 | | 100 |
| **НИЙТ** | | 1.661,300.6 | 1,660,512.0 | | |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус онд ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц 241,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарлагдсан 51,950.0 мянган төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд 11,000.0 мянган төгрөгийг олгож санхүүжилтийг зориуллалтын дагуу зарцуулж ажилласан.

Нэмэлт санхүүжилтээр 303,950.0 мянган төгрөг зарцуулан ажиласан.Үүнээс:бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо интернэтийн төлбөр, тавилга, урсгал засвар, хичээл үйлдвэрлэлийн дадлага, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж, 303,950.0 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

*/мянган төгрөг/*

| № | Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга | Бараа ажил үйлчилгээний нэр | Төлөвлөлт | Гүйцэтгэл |
|---|---|---|---|---|
| 1 | Шууд гэрээ байгуулах/Эс эс софт/ | Байгууллагын гадна,дотно камержуулалт, вирусын программ, сүлжээний багц | 3,965.5 | 3,965.5 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 2 | Шууд гэрээ байгуулах /Эгэл дулаан ХХК/ | Аймгийн ахмадын сувилалын цагаан хэрэглэл, тоног төхөөрөмж шинэчлэх | 80,000.0 | 80,000.0 |
| 3 | Шууд гэрээ байгуулах /Эгэл дулаан ХХК/ | Улаан хаалгын амралт сувиллын байр засварын ажил | 79,976.1 | 79,976.1 |
| 4 | Шууд гэрээ байгуулах /Их гурван байшинт/ | Загвар төвийн урсгал засвар | 13,000.0 | 13,000.0 |
| 5 | Шууд гэрээ байгуулах /Ширээ ХХК/ | Ухаалаг дэлгэц, суурин компьютер, принтер, нөтбүүк, угтвар ширээ, хурлын ширээ, сандал | 27,000.0 | 27,000.0 |
| **ДҮН** | | | **203,941.6** | **203,941.6** |

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсувд гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 2,567,989.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 51,359.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 41,087.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлын хувь хэмжээг өөрчлөөгүй тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэн, үр дүнгийн тайлангийн 2,567,989.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 51,359.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 41,087.8 мянган төгрөгөөр хэвээр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 35 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 6 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдэж аудитаар алдаа илрээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд 2,286.7 мянган төгрөгийн зөрчилд 1 заалт зөвлөмж өгсөн байна. /Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14-р зүйлийн 14.3.1 анхан шатны баримт бүрдүүлэх гэж заасныг мөрдөж ажиллах"/ өгсөн бөгөөд хэрэгжилт - 100% баталгаажсан-

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | | | | | |
| Зөвлөмж | 1 | 2,286.7 | 1 | 2,286.7 | 100% |
| **Нийт дүн** | **1** | **2,286.7** | **1** | **2,286.7** | **100%** |

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тус байгууллагын хөрөнгийн тооллогын бүртгэлд 2012 бүртгэлд тусгасан 141 ш бүхий 374,384.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 200ш бүхий 214,392.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй байна.Энэ нь"үнэлгээ ба хуваарилалт" "ангилал" гэсэн батламж мэдэдэлтэй нийцэхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 78,262.0 мянган төгрөгийн алдааг залруулан 10,097.2 мянган төгрөгийн алдаа илэрч зөвлөмж өгсөн.

***Залруулсан алдаа:***

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар 2024 оны санхүүгийн тайланд Алдархаан сумын Улаанхаалгын амралт сувиллын байрны урсгал засварын ажлын 75,262.0 мянган төгрөгийг барилга байгууламжаар бүртгэсэн нь "үнэлгээ ба хуваарилалт" "ангилал" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байгааг залруулан тайлан гаргуулсан.

**Шийдвэрлэсэн байдал:** залруулж тайлан гаргасан

**5.1 Төлбөрийн акт тогтоогдоогүй**

**5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

**5.3 Зөвлөмж**

Байгууллагын үйлчилгээний Ланд-200 автомашины засварт 9000,0 мянган төгрөгийг техникийн коимссын шийдвэргүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”,"нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна байна.

Тус байгууллагын хөрөнгийн тооллогын бүртгэлд 2012 бүртгэлд тусгасан 141 ш бүхий 374,384.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 200ш бүхий 214,392.3 мянган төгрөгийн тавилга эд хогшил элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй байна.Энэ нь"үнэлгээ ба хуваарилалт" "ангилал" гэсэн батламж мэдэдэлтэй нийцэхгүй байна.

Байгууллагын албан хэрэгцээнд зарцуулсан бензин болон дизелийн түлш нь "И" баримтаар нотлогдож байгаач зарцуулалтын жолоочийн замын хуудсыг дутуу бөгөлсөн хариуцагчийн гарын үсгийг дутуу зуруулсан 1,097.2 төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, " иж бүрэн байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. Иймд:

**Өгсөн зөвлөмж:**

Уг зөрчлийг арилгуулахаар доорх зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган төсвийг зориулалтын дагуу зарцуулж Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”-заалтыг мөрдөж ажиллах
2. Хөрөнгийн тооллогын бүртгэлд 2012 бүртгэлд тусгасан 141 ш бүхий 374,384.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 200ш бүхий 214,392.2 мянган төгрөгийн тавилга эд хогшил элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй хөрөнгүүдийг дахин үнэлэх
3. Байгууллагын үйлчилгээний автомашины жолоочийн замын хуудсыг бүрэн хөтөлүүлж хариуцагчийн гарын үсгээр баталгаажуулан шатахууныг зарлага болгож байх

Дээрх зөвлөмжийг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасны дагуу төлөвлөгөө гарган хэрэгжүүлж, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 15-ны дотор Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ үү.

Нийт илрүүлсэн илэрч 10,097.2 мянган төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, материаллаг шинж чанартай алдаа илрээгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруу-лаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Алдархаан сумын Улаанхаалгын амралт сувиллын байрны урсгал засварын ажлын 75262085 төгрөгийг барилга байгууламжаар бүртгэсэн нь "үнэлгээ ба хуваарилалт" "ангилал" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. | 1 | 75,262.0 | | | | | 1 | 75,262.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| **Дүн** | **1** | **75,262.0** | | | | | **1** | **75,262.0** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

*/мянган төгрөгөөр/*

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Байгууллагын үйлчилгээний Ланд-200 автомашины засварт 9000000 төгрөгийг техникийн коимссын шийдвэргүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах","нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна байна. | 1 | 9000,0 | | | | | 1 | 9000,0 | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Тус байгууллагын хөрөнгийн тооллогын бүртгэлд 2012 бүртгэлд тусгасан 141 ш бүхий 374384454.10 төгрөгийн тоног төхөөрөмж, 200ш бүхий 214392282.60 мянган төгрөгийн тавилга эд хогшил элэгдлээ бүрэн нөхсөн үлдэх өртөггүй байна.Энэ нь"үнэлгээ ба хуваарилалт" "ангилал" гэсэн батламж мэдэдэлтэй нийцэхгүй байна. | 1 | | | | | | 1 | | | | | |
| Байгууллагын албан хэрэгцээнд зарцуулсан бензин болон дизелийн түлш нь "И" баримтаар нотлогдож байгаач зарцуулалтын жолоочийн замын хуудсыг дутуу бөгөлсөн хариуцагчийн гарын үсгийг дутуу зуруулсан 1097200 төгрөгийн зөрчил илэрсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалт, " иж бүрэн байх" батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна. | 1 | 1,097.2 | | | | | 1 | 1,097.2 | | | | |
| **Дүн** | **3** | **10,097.2** | | | | | **3** | **10,097,2** | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

**ХЯНАСАН:**

АУДИТЫН МЕНЕЖЕР: Х.БОЛДБААТАР

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-ҮНДРАА

Огноо: 2025-02-19

**БОЛОВСРУУЛСАН:**

"ХААН СОЁМО АУДИТ" ХХК АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН

Огноо: 2025-02-19